



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 10 сарын 30 өдөр

Дугаар 484

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга
хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн “Налайх АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн 2017 он, 2018 оны эхний хагас жилийн байдлаар хийсэн удирдлага, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар нийт 25.5 сая (хорин таван сая таван зуун мяанган) төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1.“Налайх АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн 2017 он, 2018 оны эхний хагас жилийн байдлаар удирдлага, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.“Налайх АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Ц.Баттулгад дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай:

2.1.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах;

2.2.Худалдан авах ажиллагааны зөрчил, дутагдал гаргасан албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцох;

2.3.Компанийн хөрөнгийг зохистой удирдах, авлага, өглөгийг бууруулах, хугацаа хэтэрсэн авлагыг шүүхийн журмаар шийдвэрлүүлэх;

2.4.Ашиглалтгүй байгаа, анхны өртгөө нөхсөн, үлдэгдэл өртөггүй болсон үндсэн хөрөнгийг актлах, худалдах асуудлыг судалж, Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулан шийдвэрлүүлэх;

2.5.Шалгалтын тайланд дурдсан зөрчил, дутагдлыг арилгах болон энэхүү тогтоолоор өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан ажиллах, биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

ЗАХИРГАА ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

Б. ГАВАА

0002!11

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 12 дугаар сарын 20-ний өдрийн
зүйлд заасныг зөрчиж худалдан авалт
хийсэн

“Напайх АЗЗА” төрийн өмчийт хувьцаат компанийн шалгалтаар илэрсэн
зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалт

Д/д	Зөрчил, дутагдлын утга	Хариуцах эзэн	Дүн /төгрөгөөр/	Зөрчил, дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
2	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, Уйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлд заасныг зөрчиж худалдан авалт хийсэн	Гүйцэтгэх захидал, холбогдох ажиллагсад	25,468,181.82	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тухай бур цахим хэлбэрээр нээлттэй ил тод зарлах, төлөвлөгөөнд тусгагдаагүй худалдан авалт хийхгүй байх
	Зөрчил, дутагдлын нийт дүн		25,468,181.82	